



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар

1/13

Мандалговь

“Аймгийн Засаг даргын Тамгын газрын
өрөөнүүдийн засвар”-ын ажлыг
хүлээн авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журмын 4.3.4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын санхүүжилтээр хийгдэж буй Аймгийн Засаг даргын Тамгын газрын өрөөнүүдийн засварын ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Э.Эрдэнэжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлчилгээний албаны дарга)

Гишүүд:

С.Ариунжаргал (Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

М.Янжиндолгор (Аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)

2. Тус ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэхийг комиссын дарга (Э.Эрдэнэжаргал)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4803150018